

Барааны тэмдэгтэй байхын учир нь

Жижиг, дунд үйлдвэрлэлд
зориулсан барааны тэмдгийн
танилцуулга



Удиртгал

Энэхүү гарын авлага нь аливаа компанийн маркетинг болон брэндийн стратегийн гол элемент болох барааны тэмдэгт зориулагдсан болно. "Барааны тэмдэгтэй байхын учир нь" нэртэй энэ хэвлэл нь Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулж гаргасан барааны тэмдгийн танилцуулга мөн бөгөөд үндэсний нөхцөлд тохируулан хийсэн хувилбар юм. Энэхүү гарын авлагыг ДООБ-аас олгосон зөвшөөрөл, заавар зөвлөмж болон дэмжлэг, Японы Патентын Газрын санхүүгийн хамтын ажиллагаанд тулгуурлан бэлтгэж, хэвлүүлсэн болно. ДООБ-ын энэ хэвлэлийн эх бичвэрийг ДООБ-ын ЖДҮ-н хэлтсийн вэб хуудаснаас (www.wipo.int/smel/) PDF хэлбэрээр (Англи, Франц, Испани, Араб, Хятад мөн Орос хэлээр) үзэж болно. Энэхүү вэб хуудсанд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн сонирхол татахуйц оюуны өмчийн асуудлаархи бусад ашигтай мэдээллүүд багтсан болно.

Уг гарын авлага нь барааны тэмдгийг бизнесийн ач холбогдол талаас нь тайлбарлахыг оролдсон юм. Гарын авлагыг уншигчдад ойлгоход дөхөм болгохын тулд жишээ, зургаар тайлбарласан бөгөөд бодит хэрэглээг голчилсон аргачлалыг хэрэглэсэн болно. Гарын авлагыг жижиг, дунд үйлдвэрүүд (ЖДҮ) өөрийн барааны тэмдгийн стратегийг бизнесийн ерөнхий стратегитай уялдуулах зорилгоор ашиглах нь зохимжтой.

Монголын Улсын Оюуны Өмчийн Газрын Дарга Н. ЧИНБАТ



Агуулга

1.	Барааны тэмдэг	3
2.	Барааны тэмдгийг хамгаалах нь	6
3.	Барааны тэмдгийн төрлүүд	15
4.	Барааны тэмдгийг ашиглах нь	17
5.	Барааны тэмдгийн эрхийг албадан хэрэгжүүлэх	21

1. Барааны тэмдэг:

Барааны тэмдэг гэж юу вэ?

Монгол Улсын Барааны тэмдэг, газарзүйн заалтын тухай одоогийн хуулинд тодорхойлсноор "Барааны тэмдэг" гэж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусдын бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх, ялгагдах чадвартай илэрхийлэл юм.



Зөвшөөрсөн: "Товь" ХК



Зөвшөөрсөн: "Мобиком" ХХК



Зөвшөөрсөн: "Оллоо" ХХК

Барааны тэмдэг нь үг, дүрс, үсэг, тоо, гурван хэмжээст дүрс, өнгө, дуу авиа, үнэр, эсхүл тэдгээрийг хосолсон байдлаар илэрхийлэгдэж болно.

Дээр дурьдсаны дагуу барааны тэмдэг нь тухайн компанийн бараа үйлчилгээг ялгахад хэрэглэгдэх аливаа илэрхийлэл байна. Зар сурталчилгааны уриа, дуу аван, үнэрийн тэмдэг нь дээрх тодорхойлолтын нөхцлийг хангаж байвал тэдгээрийг барааны тэмдгээр бүртгэх боломжтой.

Үгэн тэмдэг:

NOMIN

Зөвшөөрсөн: Номин трейд ХХК

Дүрсийн тэмдэг:



Зөвшөөрсөн: "Зоос" банк

Хосолмол тэмдэг:



Зөвшөөрсөн: "Наран трейд" ХХК

3 хэмжээст тэмдэг:



Зөвшөөрсөн: "Нэн шинэ" ХХК

Барааны тэмдгийн зорилго юу вэ?

Барааны тэмдгийн үндсэн зорилго нь хэрэглэгчид тодорхой нэг компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг таних, өрсөлдөгчийн ижил буюу төсөөтэй бүтээгдэхүүнээс ялгахад оршино. Тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэж дассан хэрэглэгч түүнийг цаашдаа тогтмол худалдан авах буюу ашиглахыг хүсдэг. Үүний тулд хэрэглэгч ижил буюу төсөөтэй бараа бүтээгдэхүүнүүдийг хялбархнаар ялгадаг байх хэрэгтэй.

Тухайн компанийг таних болон түүний бараа бүтээгдэхүүнийг өрсөлдөгчийнхөөс нь ялгах боломжийг олгодог ороо барааны тэмдэг нь тухайн компанийн брэндийн болон маркетингийн хэтийн бодлогод чухал үүрэг гүйцэтгэх ба хэрэглэгчийн нүдэнд компанийн бараа бүтээгдэхүүний нэр хүнд, дүр төрхийг тодорхойлж байдаг.

Компанийн нэр хүнд, гадаад төрх нь компанийн биет бус баялгийг нэмэгдүүлж, байнгын үйлчлүүлэгч, хэрэглэгчтэй болохын үндэс суурь болдог.

Хэрэглэгч нь тухайн барааны тэмдэгтэй бүтээгдэхүүнээс зарим өөрийн хүсэж буй онцлог шинж болон чанарыг олж авдаг учраас тэд тухайн барааны тэмдэгт сэтгэлзүйн хувьд татагддаг.

Түүнчлэн барааны тэмдэг нь компаниудад өөрсдийн барааны тэмдэг бүхий бүтээгдэхүүнээ илүү нэр хүндтэй байх нөхцлийг хангах үүднээс тэдгээр бүтээгдэхүүнийхээ чанарыг хадгалах, дээшлүүлэхэд зориулж хөрөнгө оруулах

сонирхлыг бий болгоно.

Барааны тэмдгийн үнэ цэнэ

Оновчтой сонгосон барааны тэмдэг нь ихэнх компанийн бизнесийн үнэ бүхий хөрөнгө болдог. Заримынх нь хувьд энэ нь тэдний компанийн хамгийн өндөр үнэ бүхий хөрөнгө байдаг.

Дэлхийд хамгийн нэртэй барааны тэмдгийн зарим болох Coca-Cola, IBM тэмдгүүдийн үнийг тооцоход тус бүр 50 тэрбум доллараас ч илүү байдаг. Учир нь хэрэглэгч барааны тэмдэг, түүний нэр хүнд, болон тухайн тэмдэгтэй холбоотой цогц чанарт үнэлгээ өгдөг бөгөөд тэд өөрсдийн мэддэг буюу тэдний шаардлагад нийцсэн барааны тэмдэгтэй бүтээгдэхүүнд илүү үнэ төлөхдөө дуртай байдаг. Иймээс сайн нэр хүндтэй барааны тэмдгийг эзэмших нь өрсөлдөөн дундаас гарч ирэх нөхцлийг бүрдүүлнэ.



Зөвшөөрсөн: "Эм Си Эс" Групп

Яагаад танай компани барааны тэмдгээ хамгаалуулах ёстой вэ?

Ихэнх бизнес эрхлэгчид өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ өрсөлдөгчийнхөөсөө ялгахад барааны тэмдгийг ашиглахыг мэддэг хэрнээ барааны тэмдгээ бүртгэлээр хамгаалуулахын чухлыг сайтар ойлгодоггүй.

Барааны тэмдгийн хуулиар хамгаалуулсан бүртгэл нь танай компанийн барааны тэмдэгтэй ижил буюу төөрөгдөлд оруулахуйц төсөөтэй тэмдгийг бусад этгээд ижил буюу төсөөтэй бараа бүтээгдэхүүнд хэрэглэхээс хамгаалах онцгой эрх олгодог юм.

Барааны тэмдгээ хамгаалуулаагүй тохиолдолд өрсөлдөгчид төөрөгдөлд оруулж болохуйц барааны тэмдгийг ижил бараа, бүтээгдэхүүнд ашигласнаар танай бараа бүтээгдэхүүнээ борлуулахад оруулсан хөрөнгө оруулалт ямар ч үр дүнгүй болно. Таны өрсөлдөгч таныхтай ижил буюу төсөөтэй барааны тэмдгийг ашиглаж байгаа бол хэрэглэгчид танай бараа, бүтээгдэхүүн гэж бодон өрсөлдөгчийн тань бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч эндүүрэх болно. Ингэснээр нэг талаар хэрэглэгчдийг төөрөгдүүлээд зогсохгүй нөгөө талаар тухайн компанийн ашиг орлого буурч, ялангуяа өрсөлдөгчийн бараа, бүтээгдэхүүн чанаргүй байвал танай компанийн нэр хүндийг ч унагах болно.

Барааны тэмдэгт өгсөн үнэлгээ болон зах зээлд бүтээгдэхүүний амжилтыг тодорхойлж байгаагаараа барааны тэмдэг чухал ач холбогдолтой ч түүнийг тухайн зах зээлд бүртгүүлэх нь нэн чухал алхам юм.

Түүнчлэн бүртгэгдсэн барааны тэмдгээ бусад компаниудад лицензээр ашиглуулж болох ба ингэснээр танай компани орлогын өөр эх үүсвэртэй болох буюу франчайзын гэрээний нөхцөл бүрдэнэ. Энэ тохиолдолд хэрэглэгчийн дунд нэр хүнд сайтай, бүртгэгдсэн барааны тэмдгийг бизнесийн амжилтад брэндийн ач холбогдлыг сайн мэддэг санхүүгийн байгууллагуудаас санхүүжилт олж авахад ашиглаж болно.

Барааны тэмдэг нь:

- Хэрэглэгч бараа бүтээгдэхүүнийг ялгах баталгаа болно.
- Компаниудад тэдгээрийн бараа бүтээгдэхүүнийг ялгах боломж олгоно.
- Арилжааны хэрэгсэл болж брэндийн дүр төрх, нэр хүндийг бий болгох үндэс нь болно.
- Лицензээр ашиглуулж болох бөгөөд шимтгэлт төлбөр авснаар орлогын шууд эх үүсвэрийг бий болгоно.
- Франчайзын гэрээний гол нөхцөл болно.
- Таны бизнесийн үнэлэшгүй хөрөнгө болно.
- Бараа бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах, хадгалахад зориулсан хөрөнгө оруулахад компаниудад дэмжлэг болно.
- Санхүүжилт олж авахад хэрэгтэй болно.

2. Барааны тэмдгийг хамгаалах нь:

Танай компани барааны тэмдгээ хэрхэн хамгаалуулах вэ?

Монгол улсад барааны тэмдгийн хамгаалалт зөвхөн бүртгүүлснээр бий болно. Зарим оронд үүнийг ашиглалтаар олж авдаг. Та Монголын Оюуны Өмчийн Газарт (МОӨГ) зохих мэдүүлгийг гарган барааны тэмдгээ бүртгүүлнэ. Одоогийн байдлаар МОӨГ-т барааны тэмдгийг бүртгүүлэх мэдүүлгийг интернэт ашиглаж гаргах боломжгүй юм.

Барааны тэмдгийн бүртгэл нь бүртгүүлсэн барааны тэмдгийн хувьд /ялангуяа ижил буюу төсөөтэй барааны тэмдгийн зөрчил гарсан тохиолдолд/ илүү хүчтэй хамгаалалт болдог. Барааны тэмдгийг бүртгүүлэхэд барааны тэмдгийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн газрын үйлчилгээг ашиглах нь зүйтэй байдаг. Монголд энэ нь зайлшгүй зүйл биш юм. Хэрэв мэдүүлэг гаргагч өөрөө хүсвэл мэдүүлгээ итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан гаргаж болно.

Танай компанийн аж ахуйн нэгжийн нэрийг бүртгүүлсэн нь хангалттай юу?

Ихэнх хүмүүс өөрийн аж ахуйн нэгжийн нэрийг бүртгүүлснээр барааны тэмдгээр хамгаалууллаа гэж үздэг. Үнэндээ энэ бол амьдралд нийтлэг тохиолддог ташаа ойлголт юм. Иймээс аж ахуйн нэгжийн нэр болон барааны тэмдгийн ялгааг ойлгох нь чухал асуудал юм. Аж ахуйн нэгжийн нэр нь таны бизнесийн бүтэн нэр болдог. Жишээлбэл: "Монкрем" ХХК. Энэхүү нэр нь танай компанийг илтгэж

байна. Аж ахуйн нэр нь ХК, ХХК гэх мэт төгсгөлтэй байх ба тухайн хуулийн этгээдийн хэлбэрийг илэрхийлсэн товчлол юм.

Харин барааны тэмдэг нь танай компанийн бараа, бүтээгдэхүүний ялгах тэмдэг юм. Нэг компани нь хэд хэдэн барааны тэмдэгтэй байж болдог. Жишээ нь Монкрем ХХК нь нэг бүтээгдэхүүнээ "Халгай" тэмдэгтэйгээр, өөр нэг бүтээгдэхүүнийг "Дэгдээхэй" тэмдэгтэйгээр борлуулж болно.

Мөн компани нь өөрийн бараа бүтээгдэхүүнээ таниулахын тулд үйлдвэрлэж байгаа бүх бүтээгдэхүүнийхээ онцгой нэг хэлбэр эсвэл бүтээгдэхүүний өвөрмөц нэр төрлөөр илэрхийлсэн онцлог барааны тэмдгийг ашиглаж болно. Зарим компаниуд аж ахуйн нэгжийн нэрээ эсвэл түүний нэг хэсгийг барааны тэмдгээр ашиглаж болох бөгөөд энэ тохиолдолд барааны тэмдгээр бүртгүүлэх хэрэгтэй. Харин таны аж ахуйн нэгжийн нэр нь барааны тэмдгийн тодорхойлолтын шаардлагад нийцэж байвал та түүнийг барааны тэмдгээр бүртгүүлж болно.

Барааны тэмдгийн бүртгэлийн мэдүүлгийг хэн гаргах вэ?

Барааны тэмдгээ бүртгүүлэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээд барааны тэмдгийн мэдүүлгийг Оюуны өмчийн газарт гаргах эрхтэй.

Компанийнхаа барааны тэмдгийг заавал бүртгүүлэх үү?

Хэдийгээр барааны тэмдгээ бүртгүүлэх албагүй ч бүртгэл нь барааны тэмдгийг зөвшөөрөлгүйгээр ашиглахаас хамгаалах онцгой эрхийг олгодог гэдгийг санахад илүүдэхгүй.

Мэдүүлгийг татгалзах үндсэн шалтгаан юу вэ?

Та болон танай компани барааны тэмдгээ сонгохдоо ямар төрлийн тэмдгийг бүртгэхээс татгалздаг тухай мэддэг байх хэрэгтэй

Доор бид Монгол улсын барааны тэмдгийн хуулиар барааны тэмдэгт тавигддаг шаардлагуудыг дурдъя. Үүнд:

Дараахь зүйлийг барааны тэмдэгт тооцохгүй:

- нийтэд дэлгэрсэн нэр томъёо, дүрс, үл ялгагдах үсэг, тоо, тэмдэгт;
- бараа, үйлчилгээний үндсэн нэр, барааны тоо, хэмжээ, жин, чанар, зориулалт, үнэ, үйлдвэрлэсэн газрын нэр, арга, хугацаа зэргийг тайлбарласан үг, дүрс;
- барааны гаднах хэв маяг, сав, баглаа, боодлын ердийн хэлбэр.

Дараахь зүйлийг барааны тэмдгээр бүртгэхгүй:

- Монгол Улсын болон гадаад улсын сүлд, далбаа, төрийн бэлгэдэл, төрийн болон төрийн бус, түүнчлэн олон улсын байгууллагын бүтэн ба товчилсон нэр, албан ёсны тэмдгээс бүрдсэн эсхүл тэдгээртэй ижил буюу

төсөөтэй бол;

- нэрд гарсан хүний бүтэн ба товчилсон нэр, хөрөг, зураг, гарын үсгийг тухайн хүний буюу түүний өв залгамжлагчийн зөвшөөрөлгүйгээр ашигласан бол;
- Монгол Улсын түүхэн хүмүүсийн нэр, зохиомол нэр, хөрөг, зураг, тэдгээрт шууд хамаарах төсөөллийн нэрийг гутаах байдлаар ашигласан бол;
- Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн нэр, дүрсийг гутаах байдлаар ашигласан бол;
- төрийн одон, медаль болон бусад шагнал, баталгаа, хяналтын албан ёсны тэмдэг, дардастай ижил буюу төсөөтэй бол;
- агуулга нь нийгмийн дэг журам, зан суртахуунд харш бол;
- бараа, үйлчилгээний уг чанар, чансаа, гарал үүсэл болон бусад шинж чанарын хувьд хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулж болзошгүй буюу худал зүйл.

Дараахь барааны тэмдгийг бүртгэхгүй:

- Монгол Улсад бүртгэгдсэн буюу бүртгүүлэхээр мэдүүлсэн адил бараа, үйлчилгээнд хэрэглэх барааны тэмдэгтэй ижил бол;
- Монгол Улсад бүртгэгдсэн буюу бүртгүүлэхээр мэдүүлсэн нэг төрлийн бараа, үйлчилгээнд хэрэглэх барааны тэмдэгтэй ижил буюу төсөөтэйгээс хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулж болзошгүй бол;
- бараа, үйлчилгээний төрөл, бүртгэгдсэн эсэхээс үл хамаарч

нийтэд түгээмэл болсон барааны тэмдэгтэй ижил буюу төсөөтэйгээс хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулах, шударга бус давуу эрх эдлэх, ашиг олох, хохирол учруулах, нэр хүндийг гутаахаар бол;

- бусдын зохиогчийн эрх буюу аж үйлдвэрийн өмчийн эрхтэй зөрчилдөхөөр бол.
- бусдын зохиогчийн эрх буюу аж үйлдвэрийн өмчийн эрхтэй зөрчилдөхөөр бол.

Аль ч тохиолдолд барааны тэмдэг нь ижил бараа бүтээгдэхүүнд хэрэглэх өмнөх нэг л тэмдэгтэй ижил буюу төсөөтэй гэж үзвэл түүнийг хүчингүй болгоно.

Иймд хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахуйц төстэй барааны тэмдгийг хэрэглэхээс зайлсхийх нь ухаалаг алхам болох юм.

Барааны тэмдгийг бүтээх болон сонгохдоо юуг анхаарах вэ?

Тохирох барааны тэмдгийг сонгох ба бүтээх нь нэн чухал алхам юм. Учир нь барааны тэмдэг бол танай компанийн маркетингийн бодлогын чухал элемент болдог. Иймээс танай бараа бүтээгдэхүүнд тохирох тэмдэг ямар байх вэ?

Мэдээж төвөгтэй биш хурдан тогтоогдохоор байна. Үүнээс гадна дараах 5 санамж нь танд ашигтай байх болно.

- Таны сонгосон барааны тэмдэг нь хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах (Мэдүүлгийг

татгалзах үндсэн шалтгаануудыг үз).

- Бүртгэгдсэн барааны тэмдэгтэй ижил эсвэл хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулахуйц төсөөтэй эсэхийг тодруулахын тулд барааны тэмдгийн хайлт хийх.
- Барааны тэмдэг нь унших бичих, үсэглэх /дуудах/, санахад хялбар байх бөгөөд бүх төрлийн зар сурталчилгаанд тохиромжтой байгаа эсэхийг нягтлах.
- Барааны тэмдэг нь Монгол хэлэнд болон экспортлох боломжтой орны хэлэнд ямар нэг зохисгүй /нэмэгдэл/ утга агуулж буй эсэхийг шалгах.
- Зохих домэйн нэр нь бүртгэгдэх боломжтой эсэхийг шалгах хэрэгтэй

Таны сонгосон барааны тэмдэг нэг буюу хэд хэдэн үгсээс бүтсэн бол тухайн үгсийнхээ далд утгыг анхаарах хэрэгтэй.

Зохиомол буюу этгээд үг: Эдгээр нь зохиомол, ямар ч бодит утга агуулгагүй үгс байдаг. Зохиомол үг нь өөрийн гэсэн ялгагдах шинж чанартай байдгаараа давуу талтай байдаг ч нөгөө талаас хэрэглэгчид ойлгоход хэцүү, зар сурталчилгаанд илүү хүч хөдөлмөр шаардагдах сул талтай. Жишээлбэл: "Сtimo" барааны тэмдэг нь ямар нэг бодит утгагүй зохиомол үг юм.



Зөвшөөрсөн: "Сtimo" ХХК

Хийсвэр тэмдэг: Сурталчилж байгаа бараа бүтээгдэхүүнтэй ямар ч холбоогүй үг ашигласан тэмдэг юм. Энэ төрлийн тэмдэг хамгаалахад хялбар боловч хэрэглэгчдийн санаанд тухайн бүтээгдэхүүн болон тэмдгийн хоорондын холбоог бий болгоход томоохон зар сурталчилгааг шаарддаг.

Жишээ нь: ELEPHANT нь гар утасны барааны тэмдэг

Битүүгээр санал болгосон тэмдэг: Тухайн бараа бүтээгдэхүүний нэг буюу түүнээс дээш шинж чанарыг утгачлан илэрхийлсэн тэмдэг юм. Ийм тэмдэг нь зар сурталчилгааны хэлбэрээр ашиглагддаг. Үүний сул тал нь зарим оронд энэ тэмдгийг тухайн бараа бүтээгдэхүүнээ хэт тайлбарласан гэж үздэг учраас бүртгэхээс татгалздаг.

Жишээ нь: SUNNY нь цахилгаан халаагуурын барааны тэмдэг бөгөөд бүтээгдэхүүн нь дулаанаар халаах буюу танай гэрийн дулааныг хадгалах гэсэн утгыг битүүгээр санал болгож байна. Тийм учраас зарим барааны тэмдгийн газрууд энэ нь бүтээгдэхүүнээ хэт тайлбарласан утгатай гэж үзээд бүртгэхээс татгалздаг.

Та ямар ч төрлийн тэмдэг сонгосон бай та өмнөх барааны тэмдгийг дуурайхаас зайлсхийх хэрэгтэй. Өрсөлдөгчийнхөө барааны тэмдгийн дүрсийг өөрчлөх эсвэл нэртэй, нийтэд түгээмэл болсон тэмдгийг дуурайх нь яагаад ч бүртгэгдэх боломжгүй байдаг.

Жишээ нь: EASY WEAR бол өсвөр үе залуучуудын хувцасны нэлээн түгээмэл болсон тэмдэг юм. Үүнтэй ижил төстэй бүтээгдэхүүнийг EEZYWARE гэсэн

барааны тэмдэг ашиглан борлуулахаар оролдох нь болчимгүй явдал бөгөөд магадгүй энэ тэмдгийг өмнөх тэмдэгтэй төөрөгдөлд оруулахаар ижил төсөөтэй гэж үзэж энэ нь бүртгэгдэх боломжгүй болж болзошгүй.

Барааны тэмдгийн бүртгэлийн үе шат

МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧ:

Эхний үе шат, та дараахь мэдээллийг агуулсан барааны тэмдгийн мэдүүлгийн маягтыг бөглөн МОӨГ-т газарт биеэр хүргэх болон шуудангаар илгээнэ.

- * барааны тэмдэг бүртгүүлэх тухай хүсэлт;
- * мэдүүлэг гаргагчийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, хаяг, харьяалал, байнга оршин суудаг буюу үйл ажиллагаа явуулдаг улсын нэр;
- * мэдүүлэг гаргагч хуулийн этгээд бол түүний оноосон нэр, хууль ёсны хаяг, зохион байгуулалтын хэлбэр;
- * мэдүүлэг гаргагч итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй байвал түүний овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, хаяг;
- * давамгайлах огноо хүсэх тохиолдолд урьд өмнө гаргаж байсан мэдүүлгийн тухай мэдэгдэл;
- * барааны тэмдгийг өнгө зааж буюу эзлэхүүний хэлбэрээр бүртгүүлэхийг хүсвэл энэ тухай мэдэгдэл;

- * барааны тэмдэг нь хамтын буюу гэрчлэх тэмдэг байвал энэ тухай мэдэгдэл;
- * барааны тэмдгийн дүрс (тусгай формат 5x7)
- * барааны тэмдэг нь кирилл, латинаас өөр үсгээр илэрхийлэгдсэн бол тухайн тэмдгийн кирилл үсгээр галигласан хөрвүүлэг, гадаад үгээр илэрхийлэгдсэн бол түүний орчуулга;
- * олон улсын ангиллын дагуу ангилсан тухайн барааны тэмдэгт хамаарах бараа, үйлчилгээний нэрс;
- * мэдүүлэг гаргагч буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг, тамга, тэмдэг.

ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР:

Бүрдэл хянах: Оюуны өмчийн газар нь мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор түүний бүрдлийг хянаж, Монгол улсын барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуульд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл мэдүүлгийг хүлээн авсан өдрөөр анхдагч огноог тогтооно.

Оюуны өмчийн газар нь мэдүүлгийг дээрх хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл 2 сарын дотор холбогдох нэмэлт, засвар хийхийг бичгээр мэдэгдэх бөгөөд энэ хугацаанд зохих нэмэлт, засвар хийж ирүүлсэн бол мэдүүлгийн анхдагч огноог түүнийг анх хүлээн авсан өдрөөр тогтооно.

Заасан хугацаанд нэмэлт, засвар хийж ирүүлээгүй бол тухайн мэдүүлгийг Оюуны

өмчийн байгууллага хүлээн авсанд тооцохгүй ба хугацаа хожимдуулж нэмэлт, засвар хийсэн бол шинээр мэдүүлэг гаргах журмын дагуу анхдагч огноог тогтооно.

Мөн чанарын шүүлт: Оюуны өмчийн газар нь мэдүүлгийн бүрдлийг хянасны дараа тухайн тэмдэг барааны тэмдэгт тооцогдох эсэх, бүртгэж болох эсэхэд шүүлт хийнэ.

Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч барааны тэмдгийг өөрчлөхөөс бусад өөрчлөлтийг мэдүүлэгтэй хийж болох бөгөөд бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалтад нэмэлт хийх бол шинээр мэдүүлэг гаргана.

Оюуны өмчийн газар нь мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 12 сарын дотор шүүлтийн дүгнэлтэд үндэслэн барааны тэмдгийг бүртгэх эсэх талаар шийдвэр гаргах бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно

Хэвлэх ба бүртгэхээс татгалзах:

Оюуны өмчийн газар нь зөвхөн бүртгэгдсэн барааны тэмдгийн ном зүй, дүрсийг хэвлэлд нийтэлнэ.

Барааны тэмдэг нь дээрх хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл Оюуны өмчийн газар энэ талаар бичгээр мэдэгдэх бөгөөд мэдүүлэг гаргагч нь 3 сарын дотор үндэслэл бүхий хариу ирүүлээгүй бол барааны тэмдгийг бүртгэхээс татгалзсан тухай эцсийн шийдвэр гаргана. Оюуны өмчийн газар

нь уг шийдвэр гарсан өдрөөс хойш 1 сарын дотор мэдүүлэг, шүүлтийн дүгнэлтийн хуулбарыг мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ.

Мэдүүлэг гаргагч нь шинжээчийн гаргасан шүүлтийн дүгнэлтийг эс зөвшөөрвөл дээрх шийдвэр хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Оюуны өмчийн газарт гомдлоо гаргаж болно.

Бүртгэл: Оюуны өмчийн газар нь барааны тэмдгийг бүртгэх шийдвэр гаргасан бол түүнийг барааны тэмдгийн улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох ба гэрчилгээ нь 10 жилийн хугацаанд хүчинтэй байна.


Хугацаа сунгах болон хүчингүй болгох:

Эзэмшигчийн хүсэлтээр, холбогдох хураамжийг төлсний үндсэн дээр барааны тэмдгийн бүртгэлийн хүчинтэй байх хугацааг тухай бүр 10 жилээр сунгаж болно. Хүсэлтийг тухайн бүртгэл хүчинтэй байх сүүлийн нэг жилд багтаан Оюуны өмчийн газарт гаргана.

Заасан хугацаанд хүсэлт гаргаагүй бол бүртгэлийн хүчинтэй байх хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор гаргаж болно.

Харин барааны тэмдэг эзэмшигч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барааны тэмдгийг 5 жилийн турш ашиглаагүй бол түүнийг хүчингүй болгоно.

Барааны тэмдгийн бүртгэлийн үе шат:



Барааны тэмдгийг хэдий хугацаанд бүртгэх вэ?

МОӨГ-ын барааны тэмдгийг бүртгэхэд шаардагдах хугацаа 12 сар бөгөөд шаардлагатай бол энэ хугацааг 6 сараар сунгаж болно.

Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт хийлгэх ямар үнэтэй вэ?

Бодит үнэ хөлс орон оронд илэрхий ялгаатай байна. Гэвч, энэ нь хийгдэх үйл ажиллагаанаас хамаарч үнийн төрлүүд өөр өөр байдаг гэдгийг сануулах нь зүйтэй юм:

1. Монгол Улсын Оюуны Өмчийн Газарт бүртгэлийн хураамж төлөгдсөн байна. Хураамж нь үндсэндээ ажил үйлчилгээний хөлс болоод улсын тэмдэгтийн хураамж гэсэн хоёр төрлөөс бүрддэг. Ажил үйлчилгээний хөлсөнд хайлт шүүлт хийлгэх, патентын эрх шилжүүлэх төлбөр зэрэг багтах ба жишээ нь хайлт шүүлт хийлгэх хөлс 20000 төгрөг байдаг. Барааны тэмдгийн гэрчилгээ олгох, гэрчилгээний хүчинтэй байх хугацааг сунгахад Улсын тэмдэгтийн хураамжийн хууль -д заасан хувь хэмжээгээр хураамжийг Улсын татварын газарт төлнө.

Хураамжийн талаар илүү тодорхой нарийвчлан мэдэхийг хүсвэл оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид эсвэл Монгол Улсын Оюуны Өмчийн Газраас тодруулж болно.

2. Та мэдүүлэг гаргахын тулд мэргэшсэн хүний зөвлөгөөг даган сонголт хийж бүртгэлийн үйл ажиллагаанд таныг төлөөлж ажиллах оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээг хөлсөлсөн үнэ төлбөр бас багтаж болно.

Таны барааны тэмдэг гуравдагч этгээдийн эрхийг зорчсон байж болохыг хэрхэн мэдэх вэ? Барааны тэмдгийн хайлт гэж юу вэ?

Барааны тэмдгийн мэдүүлэг өгөхийн өмнө барааны тэмдгийн хайлтыг зөв хийсэн байх ёстой. Үүнийг таны ашиглаж байгаа буюу ашиглахыг хүсэж буй барааны тэмдэг, эсвэл түүнтэй төстэй барааны тэмдгийг өөр нэг компани ижил буюу төсөөтэй бараа бүтээгдэхүүнд ашиглахаар бүртгүүлсэн эсэхийг шалгахын тулд хийдэг.

Барааны тэмдгийн хайлтыг та өөрөө шууд хийх, эсвэл та барааны тэмдгийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид хандан хийлгэж болно. Хайлтыг МОӨГ-т хандан барааны тэмдгийн мэдээллийн санд хийж болно. Одоогоор МОӨГ нь урьдчилсан хайлтад бага хэмжээний хураамж авдаг. Гэхдээ энэ нь зөвхөн барааны тэмдгийн урьдчилсан хайлт гэдгийг санах хэрэгтэй. Таны сонгосон барааны тэмдэг өмнө нь бүртгэгдэн хүчин төгөлдөр болсон барааны тэмдэгтэй төөрөгдөлд орууулахаар ижил биш гэдгийг нотлох нь хэцүү юм. Энэ тохиолдолд Оюуны өмчийн газар болон шүүхийн туршлагыг сайтар мэдэх барааны тэмдгийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зөвлөгөө танд хэрэгтэй. Удахгүй МОӨГ нь барааны тэмдгийн төлбөргүй online мэдээллийн сантай болохоор ажиллаж байгаа тул та өөрөө урьдчилсан хайлт хийх боломжтой болох юм. Мөн та ДООБ-ын дараахь вэб хуудаснаас Барааны тэмдгийн мэдээллийн сангийн жагсаалтыг олох боломжтой.

<http://ecocommerce.wipo.int/trademark/index.html>

Ангиллын түгээмэл систем

Барааны тэмдгийн бүртгэлийн мэдүүлэг гаргах үедээ та бүртгүүлэхээр хүсэж буй барааны тэмдгийнхээ бараа болон үйлчилгээний ангиллыг тодорхойлох хэрэгтэй. Энэ ангилал нь барааны тэмдгийн ангиллын системийн ангид хамаарах ёстой. Барааны тэмдгийн ангиллын систем нь бүртгэгдсэн барааны тэмдгийн мэдээллийг хамаарах бараа үйлчилгээний төрлөөр дэс дараалалтайгаар ангилах боломжийг бүрдүүлдэг. МОӨГ нь Бараа үйлчилгээний олон улсын ангиллын Ниццийн системийг мөрддөг бөгөөд энэ нь барааны 34, үйлчилгээний 11 ангитай байдаг.

Ниццийн ангиллын системийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт II -оос үзээрэй.

Бараа бүтээгдэхүүнийг хэрхэн ангилдаг вэ?. Жишээ татвал : хэрэв танай компани хутга, сэрээ үйлдвэрлэдэг бол та мэдүүлгээ 8-р ангиллаар гаргах ёстой. Тэгсэн ч та өөр төрлийн гал тогооны хэрэгслийг (сав суулга, хайруулын таваг) г.м өмнөхтэйгээ ижил тэмдэг ашиглан арилжаалах бол мэдүүлгээ 21-р ангиар гаргах хэрэгтэй. Зарим оронд бараа үйлчилгээний анги тус бүрээр нэг мэдүүлэг гаргадаг бол Монголд хэд хэдэн ангийг зөвхөн нэг мэдүүлэгт хамруулж болно. МОӨГ нь мөн Дүрс-Тэмдгийн олон улсын Венийн ангиллын системийг ашигладаг.

Барааны тэмдгийн мэдүүлэг гаргахад танд оюуны өмчийн итгэмжлэгдсэн толоологч хэрэгтэй юу?

МОӨГ нь таныг барааны тэмдгийн мэдүүлэг гаргахад заавал итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлбөртэй үйлчилгээг авахыг шаардахгүй. Та мэдүүлгээ МОӨГ-т шууд гаргаж болно. Гэхдээ итгэмжлэгдсэн төлөөлөгч нь барааны тэмдгийн хайлт болон бүртгэлийн нарийвчилсан үйл ажиллагаанд илүү мэргэшсэн чадварлаг үйлчилгээ үзүүлж таны цаг завьг хэмнэж, барааны тэмдгээ тохирох ангилалд хамгаалуулахад тусалж, татгалзах үндсэн шалтгаанаас найдвартай хамгаална. Хэрэв та гадаадад барааны тэмдгээ бүртгүүлэхийг хүсвэл танд тухайн улсын барааны тэмдгийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн туслалцаа шаардлагатай болно. МОӨГ танд энэ талаар зөвлөгөө өгч, албан ёсоор батлагдсан итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн талаархи мэдээллээр хангана. (Хавсралт I-ийг үзнэ үү)

Таны бүртгэгдсэн барааны тэмдэг нь ямар хугацаанд хамгаалагдах вэ?

Барааны тэмдгийн бүртгэл нь анхдагч огнооноос эхлэн 10 жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн хугацааг тухай бүр 10 жилээр сунгаж болно

Монгол дахь таны барааны тэмдгийн бүртгэл нь олон улсад хүчинтэй юу?

Барааны тэмдгийн бүртгэлийн эрхзүй нь тухайн нутаг дэвсгэрээр хязгаарлагдана. Иймээс МОӨГ дахь таны барааны тэмдгийн хүчинтэй бүртгэл нь (нийтэд түгээмэл болсон тэмдгээс бусад тохиолдолд) Монгол улсын нутаг дэвсгэр дээр л хүчинтэй байна.

Та барааны тэмдгээ гадаадад хамгаалуулах талаар анхаарах хэрэгтэй юу?

Та өөрийн орондоо барааны тэмдгээ бүртгүүлсэн байх нь бараа бүтээгдэхүүнээсээ гадаадын зах зээлд ашиг орлого олох үндэс тавигдана.

Иймд та одоогоор экспортын үйл ажиллагаа явуулж байгаа эсвэл ойрын ирээдүйд ийм үйлчилгээ явуулахаар төлөвлөж байгаа бол барааны тэмдгээ гадаадад бүртгүүлэх нь зүйтэй юм. Ялгагдах чадвар бүхий барааны тэмдэгтэй бараа бүтээгдэхүүнийг экспортоор нийлүүлснээр таны бүтээгдэхүүн гадаадын зах зээлд танигдах төдийгүй гадаадын хэрэглэгчдийн дунд өөрийн нэр хүнд, дүр төрхөө бий болгож улмаар компанийн ашиг орлого нэмэгдэх боломжтой болно.

Барааны тэмдэг бүтээх гадаад эх сурвалж

Барааны тэмдгийн загвар хийх нь нэг төрлийн уран бүтээлийн үйл ажиллагаа юм. Ихэнх оронд уран бүтээлч нь барааны тэмдгийн дүрс зургийнх нь хувьд зохиогчийн эрхийг шууд эзэмшинэ. Ийм учраас барааны тэмдгийн бүтээх нь гадаад эх сурвалжтай байвал эх гэрээнд зохиогчийн эрхийн эзэмшигчийг тодорхойлох эсвэл тухайн барааны тэмдгийн зохиогчийн эрх нь танай компанид албан ёсоор шилжсэнийг тодорхой заах хэрэгтэй юм.

Та барааны тэмдгээ гадаадад хэрхэн бүртгүүлж болох вэ?

Та компанийнхаа барааны тэмдгийг Монголд бүртгүүлсэн хэдий ч цаашид барааны тэмдэгтэй бүтээгдэхүүнээ экспортлох эсвэл бусад оронд лицензээр ашиглуулахыг хүсвэл барааны тэмдгээ гадаадад бүртгүүлэх зайлшгүй шаардлагатай. Үүнийг үндсэн хоёр аргаар хэрэгжүүлнэ. Үүнд:

Үндэсний мэдүүлэг гаргах: Танай компани өөрийнхөө барааны тэмдгийг аль улсад хамгаалуулах хүсэлтэй байна вэ тэр улсынхаа барааны тэмдгийн газарт хүсэлт гаргана. Ингэхдээ мэдүүлгийг тухайн улс бүрийн шаардагдах хэл дээр гаргаж, зохих хураамжийг төлнө.

Энэ тохиолдолд зарим орны хувьд үндэсний (тухайн орны) итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээг ашиглахыг шаарддаг.

Олон улсын мэдүүлэг гаргах: Монгол улс Мадридын системийн гишүүн орон юм. Хэрэв таны барааны тэмдэг Монгол улсад хүчинтэй, бүртгүүлсэн эсвэл бүртгүүлэхээр мэдүүлсэн бол Мадридын системийг ашиглан түүний гишүүн 70 гаруй оронд барааны тэмдгээ бүртгүүлж болно.

Мадридын системийн давуу талууд

Мадридын системийн гол давуу тал нь барааны тэмдэг эзэмшигч энэ системийн гишүүн аливаа оронд тогтсон хугацаанд

- Олон улсын нэг мэдүүлгээр
- Нэг хэлээр
- Нэг иж бүрдэл хураамжаар барааны тэмдгээ бүртгүүлэх ба хугацаа дуусвал нэг хүсэлтээр олон улсын бүртгэлийг шинэчилж болно.

Та барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг МОӨГ болон ДОӨБ-ын дараахи вэб хуудаснаас үзээрэй.

www.wipo.int/madrid/

www.ipom.mn

2. Барааны тэмдгийн төрлүүд

Барааны тэмдэг	Аливаа компанийн үйлдвэрлэж буй бараа, бүтээг дэхүүнийг бусдынхаас ялгах тэмдэг
Үйлчилгээний тэмдэг	Аливаа компанийн үзүүлж буй үйлчилгээг бусдын хаас ялгах тэмдэг
Хамтын тэмдэг	Холбооны гишүүдийн үйлдвэрлэж байгаа бараа болон үзүүлж буй үйлчилгээг ялгах тэмдэг.
Гэрчлэх тэмдэг	Эрх бүхий байгууллагаас гэрчилсэн, тогтоосон шаардлагыг хангасан бараа үйлчилгээг ялгах тэмдэг
Нийтэд түгээмэл болсон тэмдэг	Зах зээлд нийтэд түгээмэл болсон бөгөөд үүний үр дүнд хүчтэй хамгаалалттай болсон тэмдэг.

Үйлчилгээний тэмдэг гэж юу вэ?

Үйлчилгээний тэмдэг нь барааны тэмдэгтэй адилхан. Хоёулаа л ялгагдах шинж чанартай. Барааны тэмдэг нь нэг компанийн барааг нөгөө компанийнхаас ялгадаг бол үйлчилгээний тэмдэг нь адил үүрэгтэй ч энэ нь гагцхүү үйлчилгээнд хамаарч байдаг. Үйлчилгээ нь банк, санхүү, аялал жуулчлал, зар сурталчилгаа, хоол бэлтгэх /зоогийн газар/ гэх мэт ямар ч төрлөөр байж болно.

Жишээ нь:



Зөвшөөрсөн: Худалдаа Хөгжлийн Банк

Хамтын тэмдэг гэж юу вэ?

Монгол улсын барааны тэмдгийн хуульд тодорхойлсноор "Хамтын тэмдэг" гэж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдлийн гишүүд тухайн нэгдлийн хяналтын дор ашиглах барааны тэмдгийг хэлнэ

Ерөнхийдөө хамтын тэмдгийг нэгдэл эзэмших боловч түүний гишүүд хамтын тэмдгийг зах зээлд өөрийн бүтээгдэхүүндээ ашиглах эрхтэй. Нэгдэл нь гол төлөв хамтын тэмдгийг ашиглах шалгуур /чанар, стандарт /-ыг тогтоох ба хэрэв энэхүү нөхцлийг хангаж байвал гишүүн компанид барааны тэмдгийг ашиглахыг зөвшөөрдөг. Хамтын тэмдэг нь нөгөө талаар жижиглэнгийн худалдаачид болон хэрэглэгчид барааны тэмдгийг нь төдийлөн танихгүй хэсэг компаниуд хамтран өөрсдийн бараа бүтээгдэхүүнээ нэгдмэл шинж чанартайгаар зах зээлд гаргах хүчтэй арга нь болдог.

Гэрчлэх тэмдэг гэж юу вэ?

"Гэрчлэх тэмдэг" гэж тухайн бараа, үйлчилгээний чанар, үйлдвэрлэх арга, бусад онцлог шинж чанарыг тэмдэг эзэмшигч гэрчлэн бусад этгээдүүдэд ашиглуулах барааны тэмдгийг хэлнэ гэж МУ-ын Барааны тэмдэг, газарзүйн заалтын тухай хуульд тодорхойлсон байдаг.

Гэрчлэх тэмдэг нь тодорхой стандартад нийцсэн байх шаардлагатай бөгөөд гишүүнчлэлээр хязгаарлагдаггүй. Ингэснээр тухайн бүтээгдэхүүн нь тогтоосон стандартыг хангаж чадах ямар

ч хүн гэрчлэх тэмдгийг ашиглаж болно. Ихэнх оронд хамтын тэмдэг болон гэрчлэх тэмдгийн гол ялгаа нь хамтын тэмдгийг үйлдвэрлэлийн нэгдлүүд, нийгэмлэгийн гишүүд ашиглаж болдог байхад гэрчлэх тэмдгийг түүний эзэмшигчийн тогтоосон стандартыг хангасан ямар ч этгээд ашиглаж болдог оршино. Гэрчлэх тэмдгийн тухайд гол шаардлага нь мэдүүлэг гаргагч этгээд тухайн бараа, бүтээгдэхүүний чанарын төвшинг хангаж чадахаа гэрчлэх чадвартай байх ёстой гэж үздэг.



Зөвшөөрсөн: Файбермарк нийгэмлэг

Жишээ нь: Энэ тэмдэг нь Монголын Файбермарк нийгэмлэгийн гэрчлэх тэмдэг юм.

Энэ тэмдэг нь тухайн ноолууран бүтээгдэхүүн нь 100% ноолуураар хийгдсэн бөгөөд Файбермарк нийгэмлэгээс тогтоосон тодорхой стандартыг хангасан гэдгийг гэрчилж буй чанарын тэмдэг юм.

Нийтэд түгээмэл болсон тэмдэг гэж юу вэ?

Нийтэд түгээмэл болсон тэмдэг гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тухайн салбарт нийтэд танил болсон тэмдгийг хэлнэ.

Ийм тэмдэг нь ерөнхийдөө илүү хүчтэй хамгаалалттай байдгаараа давуу талтай. Жишээ нь тухайн нутаг дэвсгэр дээр бүртгэгдээгүй байсан ч (эсвэл ашиглагдаагүй ч) нийтэд түгээмэл болсон тэмдэг нь шууд хамгаалагдана. Түүнчлэн барааны тэмдгийг нэг төрлийн бараа үйлчилгээнд хэрэглэгдэх төөрөгдөлд оруулахаар ижил барааны тэмдгээс хамгаалдаг бол нийтэд түгээмэл болсон тэмдгийг тодорхой нөхцлүүд бүрдсэн тохиолдолд бараа үйлчилгээ хамааралгүй, төөрөгдөлд оруулахаар ижил барааны тэмдгийн эсрэг ямагт хамгаалдаг. Энэхүү хүчтэй хамгаалалтын үндсэн зорилго нь хуулийн этгээдийн нийтэд түгээмэл болсон тэмдгийн нэр хүндийг чөлөөтэй ашиглахаас хамгаалах буюу түүний нэр хүнд болон туршлагад сэв суулгахаас сэргийлнэ.

Жишээ нь: WONDERCOLA-г нэгэн алдартай ундааны барааны тэмдэг гэж төсөөлж үзье. Тэгвэл Wondercola компани нь нийтэд түгээмэл болсон тэмдэг нь хүчтэй хамгаалалттай байдаг эсвэл ундааны хувьд барааны тэмдэг нь нийтэд түгээмэл болсон улс орнуудад хүчтэй хамгаалалтаар хангагдах давуу талтай. Энэ хамгаалалт нь барааны тэмдэгт хамааралгүй бараа үйлчилгээнд ч мөн адил үйлчилдэг. Өөрөөр хэлбэл өөр нэг хуулийн этгээд WONDER COLA барааны тэмдгийг ашиглан биеийн тамирын цамц, нүдний шил зэрэг

өөр бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахаар шийдвэрлэсэн бол WONDER COLA компаниас албан ёсны зөвшөөрөл авах ёстой, хэрэв үгүй бол барааны тэмдгийн эрхийг зөрчсөн асуудалд орох эрсдэлтэй болно.

Та барааны тэмдгээ ашиглаагүй байж бүртгүүлж болох уу?

Та барааны тэмдгээ ашиглахаасаа өмнө МОӨГ-т бүртгүүлж болох боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 5 жилийн хугацаанд ашиглаагүй бол түүнийг барааны тэмдгийн бүртгэлээс хасна.

ТМ буюу ® юу гэсэн утгатай вэ?

Барааны тэмдгийн ард ®, ТМ, SM эсвэл үүнтэй ижил тэмдэгтийг заавал хэрэглэх шаардлагагүй бөгөөд ямар нэгэн эрх зүйн хамгаалалтыг олгодоггүй. Энэ тэмдэг нь барааны тэмдэг гэдгийг бусдад мэдээлж, тухайн тэмдгийг зөрчих, хууль бусаар үйлдвэрлэх зэргээс хамгаалах тохиромжтой нэг арга байж болно. ® тэмдэгтийг бүртгэгдсэн барааны тэмдэгт, ТМ нь тухайн тэмдэг нь барааны тэмдэг гэдгийг тус тус илтгэдэг бол зарим тохиолдолд SM-г үйлчилгээний тэмдэгт хэрэглэдэг байна.

Зар сурталчилгаанд барааны тэмдгээ хэрхэн ашиглах вэ?

Хэрэв таны барааны тэмдэг өвөрмөц загвар, үсгийн иж бүрдлээр бүртгэгдсэн бол барааны тэмдгээ бүртгэгдсэн энэ хэлбэрээрээ ашиглахыг анхаарах хэрэгтэй. Энэ нь танай компанийн бараа бүтээгдэхүүний нүүр царайнд хэрхэн

нөлөөлж байгаад ойр ойрхон хяналт тавих нь зүйтэй. Түүнчлэн барааны тэмдгийг нэр үг болон үйл үг болгон хэрэглэхээс зайлсхийх нь чухал, хэрэв тэгэхгүй бол хэрэглэгчид барааны тэмдгийг ердийн үг мэтээр хүлээж авах болно.

Танай компани хэд хэдэн төрлийн бараа, бүтээгдэхүүнд нэг ижил барааны тэмдгийг ашиглаж болох уу?

Өөр өөр барааны тэмдгийг компанийнхаа өөр өөр бараа бүтээгдэхүүнд ашиглаж болно. Брэндийн бодлогоос хамааран компани нь шинэ бүтээгдэхүүн гаргах бүрдээ үргэлжлүүлэн нэг барааны тэмдгийг бүх бүтээгдэхүүндээ хэрэглэх үү эсвэл бүтээгдэхүүний төрөл бүрдээ өөр өөр тэмдэг хэрэглэх үү гэдгийг шийднэ.

Брэндээ өргөжүүлэн шинэ бүтээгдэхүүндээ ижил тэмдэг ашигласнаар уг шинэ бүтээгдэхүүн нь тухайн тэмдгийн хүрсэн нэр хүндээс ашиг олох боломжийг бүрдүүлэх талтай. Гэхдээ шинэ бүтээгдэхүүнтэйгээ холбоотой онцлог шинэ тэмдэг ашиглах нь уг компанид тодорхой бүлэг хэрэглэгчдэд /хүүхэд, өсвөр үе, эмэгтэйчүүд/ зориулсан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт тавих, түүнчлэн шинэ бүтээгдэхүүнийхээ өвөрмөц нэр хүндийг бий болгох давуу талтай. Олон компаниуд өмнөх брэндтэйгээ холбоотой онцлог тэмдгийг бий болгох замыг сонгож байна.

Жишээ нь: Монкрем ба Ганга, Солонго:



Зөвшөөрсөн: "Монкрем" ХХК

Компани бүр өөр өөрийн хэтийн бодлоготой байдаг. Таны сонголт ямар ч байсан та аливаа бараа үйлчилгээндээ ашиглаж байгаа, ашиглах гэж байгаа барааны тэмдгүүдээ бүртгүүлсэн байх ёстой.

Та барааны тэмдгээ интернэтэд ашиглахдаа юуг анхаарах вэ?

Барааны тэмдгийг интернэтэд ашиглахад эрхзүйн маш олон түвэгтэй шинэ асуудлууд бий болдог. Бэрхшээлтэй тал нь интернэт дэлхий нийтийг хамарсан байхад барааны тэмдгийн эрх нь нутаг дэвсгэрийн шинж чанартай гэсэн зарчмаас урган гарсан. Энэ нь янз бүрийн оронд ижил төрлийн бараа үйлчилгээнд төөрөгдөлд оруулахаар ижил барааны тэмдгийг хуулийн дагуу эзэмшиж байгаа хувь хүн эсвэл хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхэд бэрхшээл учирч байна. Энэ чиглэлийн хууль тогтоомж

боловсронгуй болж байгаа ч энэ нь улс улсаас ялгаатай байна.

Домэйн нэр гэж юу вэ? Барааны тэмдэгт хэрхэн хамаарах вэ?

Барааны тэмдэг болон домэйн нэр хоорондын зөрчилдөөн нь чухал асуудал юм. Жишээ нь домэйн нэр нь интернэтийн хаяг бөгөөд гол төлөв вэб хуудсыг хайхад ашиглагддаг. Жишээ нь wipo.int гэсэн домэйн нэрийг ДОӨБ-ын <http://www.wipo.int>. вэб хуудсыг олоход ашигладаг.

Домэйн нэрэнд бизнесийн үйл ажиллагааны тодорхойлогч зүйлүүд багтдаг учраас барааны тэмдэгтэй зөрчилдөхөд хүрдэг байна. Иймд та өөр этгээдийн барааны тэмдэг ялангуяа нийтэд танил болсон тэмдэгтэй андуурагдахааргүй домэйн нэрийг сонгон авах хэрэгтэй. Яагаад гэвэл үндэсний олон хууль тогтоомж болон шүүх өөр этгээдийн буюу хувь хүний барааны тэмдгийг домэйн нэрээр бүртгүүлэхийг барааны тэмдгийн зөрчил гэж үздэг бөгөөд үүнийг нийтэд цахим хулгай гэж нэрлэдэг.

Хэрэв ийм зүйл тохиолдвол таны бизнесийн үйл ажиллагааг шилжүүлэх интернэтийн хаягийн нэрийг хүчингүй болгох төдийгүй хохирлыг барагдуулах буюу их хэмжээний торгууль төлөх болно. Тухайн барааны тэмдэг хамгаалагдсан эсэхийг мэдэхийн тулд та МООГ-т хандах буюу ДОӨБ-ын дараахь вэб хуудас дахь барааны тэмдгийн мэдээллийн сангаас интернэтийн хайлт хийх боломжтой юм.

ecommerce.wipo.int/databases/trademark/

Нөгөө талаас танай компанийн барааны тэмдгийг өөр хуулийн этгээд, хувь хүн ашиглаж, цахим хулгай хийсэн бол та энэ зөрчлийг зогсоохыг шаардах эрхтэй. Энэ тохиолдолд домэйн нэртэй холбоотой маргааныг ДОӨБ-ын онлайн маргаан шийдвэрлэх төвд хандах боломжтой.
<http://arbiter.wipo.int/domains/>.

Та барааны тэмдгээ бусад компанид лицензээр ашиглуулж болох уу?

Барааны тэмдгийг өөрийн бараа үйлчилгээг бусдынхаас ялгах үндсэн зорилгоос үл хамааран өөр хуулийн этгээдэд лицензийн гэрээгээр ашиглуулж болно. Энэ тохиолдолд барааны тэмдэг эзэмшигч өмчлөх эрхийг эзэмших ба тухайн барааны тэмдгийг ашиглах зөвшөөрлийг нэг буюу хэд хэдэн хуулийн этгээдэд олгож болно. Үүнийг албан ёсны лицензийн гэрээнд тодорхой заасан барааны тэмдэг эзэмшигчийн зөвшөөрлийг үндэслэн төлбөрийн үндсэн дээр хийнэ. Гэрээний нөхцлөөс хамааран лиценз олгогч нь тодорхой чанарыг хадгалахын тулд лиценз авагчдаа хяналт тавих эрхтэй. Бодит амьдрал дээр, барааны тэмдгийн лицензийг франчайзын гэрээ эсвэл патент, ноу-хау, тухайн бүтээгдэхүүнд техникийн тусламж дэмжлэг үзүүлэх зэрэг оюуны өмчийн бусад эрхүүдийг хамруулсан өргөн хүрээтэй лицензийн гэрээгээр олгодог

Франчайзын гэрээ барааны тэмдэгт ямар хамааралтай вэ?

Барааны тэмдгийн лизенз олгох нь франчайзын гэрээний гол нөхцөл нь байдаг. Франчайзын гэрээнд барааны тэмдэг эзэмшигчээс Франчайз авагчид тавих хяналтын хэмжээ ердийн лицензийн гэрээнийхээс илүү байна. Франчайзын гэрээ хийх тохиолдолд франчайз олгогч нь үйл ажиллагааны /барааны тэмдэг, Ноу- хау, худалдааны үйлчилгээ, програм хангамж, дэлгүүр чимэглэл/ арга хэлбэрийг франчайзын гэрээний нөхцлийн дагуу тодорхой төлбөрийн үндсэн дээр зөвшөөрдөг.

Та компанийнхаа барааны тэмдгийг бусад этгээд худалдах болон эрх шилжүүлэхэд ямар нэг хязгаарлалт байх уу?

Одоогийн явуулж байгаа үйл ажиллагаанаас үл хамааран барааны тэмдгээ худалдах эсвэл эрхийг шилжүүлэх өргөн бололцоотой юм. Худалдах буюу эрх шилжүүлэх тохиолдолд гэрээг МӨӨГ-т бүртгүүлж, нэг хувийг нь МӨӨГ-т хадгална.

Та барааны тэмдэгтээ хийсэн аливаа жижиг өөрчлөлтүүдийг бүртгүүлэх шаардлагатай юу?

Ихэнхи барааны тэмдэг, тэр дундаа нийтэд түгээмэл болсон тэмдгүүд нь хуулийн этгээдийн дүр төрхийг орчин үед нийцүүлэх эсвэл шинэ зар сурталчилгааны хэрэгсэлд тохируулах үүднээс бага зэрэг өөрчлөгдөх буюу олон жилийн хугацаанд хувирсаар байдаг. Иймд барааны тэмдгүүд өөрчлөгдөн шинэчлэгдэж болно. Гэхдээ

танай компани үүнд болгоомжтой хандах ёстой бөгөөд МӨӨГ, эсвэл эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгчтэйгээ зөвлөлдөх, харин ач холбогдол бүхий өөрчлөлт хийвэл шинэ мэдүүлэг гаргаж, холбогдох хураамж төлж шинээр бүртгүүлнэ.



5. Барааны тэмдгийн эрхийг албадан хэрэгжүүлэх:

Таны барааны тэмдгийг бусад этгээд зөвшөөрөлгүйгээр ашигласан бол яах ёстой вэ?

Барааны тэмдгийн эрхийг албадан хэрэгжүүлэх нь барааны тэмдэг эзэмшигчдэд тохиолддог гол бэрхшээл юм. Танай компани барааны тэмдэг эзэмшигчийн хувьд аливаа зөрчлийг илрүүлэх буюу барааны тэмдгийн эрхээ албадан хэрэгжүүлэх талаар ямар арга хэмжээ авахаа өөрөө шийднэ гэсэн үг юм.

Хэрэв таны барааны тэмдгийн эрхийг хэн нэгэн этгээд зөрчиж байна гэж үзвэл мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй юм. Ер нь оюуны өмчийн хуульч өөрийн

оронд төдийгүй хөрш орнуудад танай компанийг аливаа зөрчил, хуурамч үйлдлээс хамгаалах арга хэмжээний талаар мэдээлэл өгөх, эрхээ хэрхэн албадан хэрэгжүүлж болох талаар зөвлөгөө өгөх боломжтой хүн мөн.

Хэрэв та барааны тэмдгийн эрхийн зөрчилтэй тулгарвал эхлээд уг зөрчсөн этгээдэд энэ байдлаас үүсч болох зөрчлийн талаар урьдчилан мэдэгдсэн захидлыг илгээж болно.

Гэхдээ энэ мэдэгдлээ бичихдээ оюуны өмчийн хуульчийн зөвлөгөөг авах нь зүйтэй.

Хэрэв танай компани тухайн зөрчлийг санаатай гэж үзэж байгаа бөгөөд тухайн зөрчил хаана болж байгааг мэдэж байвал зөрчил гаргасан этгээд болон хуулийн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр хураах болон нэгжих зөвшөөрлийг /ОӨГ, харьяалагдах шүүх, цагдаагаас/ авснаар эрх бүхий байгууллага нь нэвтрэн орох, гэнэтийн арга хэмжээ авч болно.

Эрх бүхий байгууллага нь зөрчилтэй бараа үйлчилгээг үйлдвэрлэсэн болон тараасан этгээд буюу тэдгээрийн тараагдсан байдлын талаар танд мэдээлэх болно.

Дээрх эрх бүхий байгууллагууд нь хураасан зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг таны хүсэлтээр ямар ч төрлийн нөхөн төлбөр олгохгүйгээр устгах буюу улсын орлого болгох шийдвэр гаргана.

Барааны тэмдэг эзэмшигч нь зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирэхээс урьдчилан сэргийлэхийн тулд

дотоодын гаалийн байгууллагаар дамжуулан олон улсын хилийн боомт дээр арга хэмжээ авах боломжтой.

Тэгэхдээ танай компани зөрчилтэй бараа бүтээгдэхүүн тухайн улсад нийлүүлэгдэхээс өмнө хил дээрх гаалийн байгууллагын туслалцааг авч болно.

Зарим тохиолдолд зөрчлийг шийдвэрлэх хамгийн үр дүнтэй арга нь арбитрын шүүх болон Зуучлалын байгууллагад хандах явдал юм.

Арбитр нь шүүхтэй харьцуулахад хүнд суртал багатай, хугацаа богино, хялбар журамтай байдгаараа давуу талтай бөгөөд арбитрын шүүхийн шийдвэр нь олон улсын хэмжээнд хялбар хэрэгжих боломжтой юм.

Зуучлал нь маргаан шийдвэрлэх процесст талууд хяналт тавьж байдгаараа давуу талтай юм.

Арбитрын шүүх болон зуучлалын талаар дэлгэрэнгүй мэдээллийг ДООБ-ын Арбитр ба Зуучлалын төвийн дараахь вэб хуудаснаас үзээрэй

[/arbiter.wipo.int/center/index.html](http://arbiter.wipo.int/center/index.html)

Нэмэлт мэдээлэл авахад ашиглагдах вэб хуудсууд

Бизнесийн талаархи бусад оюуны өмчийн асуудлууд:

www.wipo.int/sme/

Барааны тэмдгийн талаар:

- Монгол улсын Оюуны Өмчийн газрын вэб хуудас: www.ipom.mn
- Оюуны өмчийн тухай ДОӨБ-ын вэб хуудас: www.wipo.int/about-ip/en/
- Олон улсын барааны тэмдгийн холбоо: www.inta.org

Барааны тэмдгийн бүртгэлийн талаар практик асуудлуудыг сонирхвол үндэсний болон бүсийн барааны тэмдгийн газруудын вэб хуудсуудыг хавсралт I-ээс эсвэл www.wipo.int/news/en/links/ipo -оос үзээрэй

Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн Мадридын системийн тухай

www.wipo.int/madrid/en

Дэлхий нийтийн аж үйлдвэрийн өмчийн газруудын барааны тэмдгийн онлайн мэдээллийн сангийн жагсаалт

ecommerce.wipo.int/databases/trademark/

Ниццийн хэлэлцээрийн дагуу барааны тэмдгийн бүртгэлийн бараа үйлчилгээний олон улсын ангилал

www.wipo.int/classification/en

Венийн хэлэлцээрийн дагуу барааны тэмдгийн дүрсийн олон улсын ангилал

www.wipo.int/classification/en

Барааны тэмдэг болон домэйн нэрийн зерчилдөөний тухай

ecommerce.wipo.int/domains/

www.icann.org

Домэйн нэрийн маргаантай асуудлын талаар

Arbiter.wipo.int/domains/

Хавсралт I

ҮНДЭСНИЙ БОЛОН БҮСИЙН БАРААНЫ ТЭМДГИЙН ГАЗРУУДЫН ВЭБ ХУУДСЫН ХАЯГ

Алжир	http://www.inapi.org	Хорват	http://pubwww.srce.hr/patent
Андор	http://www.ompa.ad	Куб	http://www.ocpi.cu
Аргентин	http://www.inpi.gov.ar/	Чех	http://www.upv.cz
АРИПО (африкийн бүсийн аж үйлдвэрийн өмчийн байгууллага)	http://www.aripo.wipo.net/	Ардчилсан Солонгос	http://www.epa.ee
Армен	http://www.armpatent.org	Дани	http://www.dkpto.dk/
Австри	http://www.patent.bmwa.gv.at/	Доминикан	http://www.seic.gov.do/onapi/
Австрали	http://www.ipaustralia.gov.au/	Египет	http://www.egypt.gov.eg
Барбадос	http://www.caipo.org	Эстони	http://www.epa.ee
Белиз	http://www.belipo.bz	Евро-Азийн Патентийн газар	http://www.eapo.org
Бельги	http://www.european-patent-office.org/patlib/country/belgium	Европын холбооны орнуудын дотоодын зах зээлийг уялдуулах газар - ОНИМ)	http://oami.eu.int/
Бенелюкс (Бенелюксийн барааны тэмдгийн газар)	http://www.bmb-bbm.org/	Финлянд	http://www.prh.fi
Боливи	http://www.senapi.gov.bo	Франц	http://www.inpi.fr
Босни Герцоговени	http://www.bih.net.ba/-zsmp	Гүрж	http://www.sakpatenti.org.ge/
Бразил	http://www.inpi.gov.br	Герман	http://www.dpma.de
Болгар	http://www.bpo.bg/	Грек	http://www.ggr.gr
Канад	http://opic.gc.ca	Унгар	http://www.hpo.hu/
Хятад	http://www.sipo.gov.ch	Исланд	http://www.els.stjr.is
Хятад (Барааны тэмдэг)	http://www.saic.gov.ch	Энэтхэг	http://www.tmrindia.com
Хятад (Гонконг -SAR)	http://www.info.gov.hk/ipd	Индонези	http://www.dgip.go.id
Чили	http://www.proind.gov.cl	Ирланд	http://www.patentsoffice.ie
Колумб	http://www.sic.gov.co	Израйль	http://www.justice.gov.il/rasham+haptentinm/default.asp
Коста Рика	http://www.registracional.go.cr	Итали	http://www.european-patent-office.org/it/
		Япон	http://www.jpo.jp

Иордан	http://www.mit.gov.jo	Конго	http://www.anpi.cg.wipo.net
Казахстан	http://www.kazpatent.kz http://www.kazpatent.org	Солонгос	http://kipo.go.kr
Кени	http://www.kipo.ke.wipo.net	Македони	http://www.ippo.gov.mk/
Киргизстан	http://www.krygyzpatent.kg	Молдави	http://www.agepi.md/
Лаос	http://www.stea.la.wipo.net/index.html	Румын	http://www.osim.ro
Литви	http://www.vpb.lt/	ОХУ	http://www.rupto.ru
Люксембург	http://www.etat.lu/ec/	Серби Монтенерго	http://yupat.sv.gov.yu
Макао	http://www.economia.gov.mo	Сингапур	http://www.ipos.gov.sg
Малайз	http://kpdnhq.gov.my	Словак	http://www.indprop.gov.sk
Мексик	http://www.impi.gob.mx/	Словени	http://www.uil-sipo.si/
Монако	http://www.european-patent-office.org/patlib/country/monaco/	Испани	http://www.oepm.es
Монгол	http://www.ipom.mn	Швед	http://www.prv.se
Морокко	http://www.ompic.org.ma/	Швейцари	http://www.ige.ch
Нидерланд	http://www.bie.minez.nl	Тажикистан	http://www.tipat.org
Нидерланд Антилын арал	http://bureau-intellectual-property.org/	Тайланд	http://www.ipthailand.org
Непал	http://www.ip.np.wipo.net	Турк	http://www.turkpatent.gov.tr
Шинэ Зеланд	http://www.iponz.govt.nz	Украйн	http://www.spou.kiev.ua
Норвеги	http://www.patentstyret.no	Англи	http://www.patent.gov.uk
Африкийн Оюуны өмчийн Байгууллага (ОАПИ)	http://www.oapi.wipo.net/	АНУ	http://www.uspto.gov
Панам	http://www.mici.gob.pa/comintf.html	Уругвай	http://www.dnpi.gub.uy
Перу	http://www.indecopi.gob.pe/	Узбекистан	http://www.patent.uz
Филиппин	http://www.ipophil.gov.ph/	Венесуэл	http://www.sapi.gov.ve
Польш	http://www.uprp.pl/		
Португали	http://www.inpi.pt/		

Хавсралт II

Ницийн хэлэлцээрийн дагуу Барааны тэмдгийн бүртгэлийн бараа ба үйлчилгээний олон улсын ангилал

БАРАА

1. Үйлдвэрийн, шинжлэх ухаан, гэрэл зураг, тэрчлэн хөдөө аж ахуй, цэцэрлэгийн аж ахуй, ойн аж ахуйд хэрэглэдэг химийн бүтээгдэхүүн, боловсруулаагүй хиймэл давирхай, боловсруулаагүй хуванцар бууц бордоо, гал унтраах бодис, хатаалга болон гагнуурын бэлдмэл, хүнсний зүйл хадгалах химийн бодис, идээлгийн бодис, үйлдвэрлэлд хэрэглэдэг цавууны бодис
2. Будаг, чий, маажин, паалан гялга, мод муудахын эсрэг болон зэврэлтийн эсрэг урьдчилан сэргийлэх бодис, өнгөлөгч, идэмхий бодис, байгалийн түүхий давирхай, төмөрлөг цаас болон чимэглэгч, хэвлэгч болон уран зургийн нунтаг будаг,
3. Цайруулагч бэлдмэл болон цагаан хэрэглэлд зориулсан бусад бодис, цэвэрлэх, өнгөлөх, гялалзуулах болон зүлгэх бэлдмэл, саван үнэртэй ус, тос, үсний тос, шүдний оо;
4. Үйлдвэрийн тос болон тосолгооны бодис, өтгөн тослогч, тоос сорох, чийчлэх болон холбогч хольц, шатахуун (хөдөлгүүрийн спиртийг оруулж) болон гэрэлтүүлэгч лаа, дэнгийн гол, дэнлүү
5. Эмийн бодис, мал эмнэлгийн болон ариун цэврийн бэлдмэл, эмнэлэгт хэрэглэх цагаан хоолны бодис, хүүхдийн хоол, шархны тууз, боолтын материал, шүд тогтоох, буйлны лав, ариутгагч, хортон шавьж устгах бэлдмэл
6. Ердийн төмөр болон түүний хайлш, барилгын төмөрлөг материал, металл хийцийн явуулын барилга, төмөр замын тэрэгний төмөрлөг материал, цахилгааны бус утас болон ердийн төмөр утас, төмөр эдлэл, төмөр эдлэлийн жижиг бүтэц, төмөр яндан болон хоолой, сейф, бусад ангилалд ороогүй ердийн төмөрлөг, үнэт металл
7. Машин болон машины багаж, мотор, хөдөлгүүр, (газрын дугуйт хэрэгслээс бусад), хос хүчний машин буюу дамжуулах бүрэлдэхүүн, гар ажиллагаатайгаас бусад ХАА-н багаж хэрэгсэл, өндөг дарагч
8. Гар төхөөрөмж, гар ажиллагаатай багаж хэрэгсэл, зүсэгч, огтлогч,.
9. Шинжлэх ухааны, газар хэмжилтийн, далайн, цахилгааны, гэрэл зургийн, кино зураглалын, хараа зүйн, жинлүүрийн, хэмжүүрийн, дохиоллын, хяналтын, амь

аврах, багшлах багаж хэрэгсэл, хэрэгсэл багаж, бичлэг хийх буюу, дуу, дүрс авиа дахин үйлдвэрлэх зөөх хэрэгсэл, соронзон өгөгдөл зөөгч, бичлэгийн диск,автомат худалдах машин, зоосоор ажиллах машин, кассын бүртгэгч, тооцох машин, өгөгдөл боловсруулах төхөөрөмж болон цахим тооцоолуур, гал унтраах төхөөрөмж хэрэгсэл

10. Мэс ажилбарын, эмнэлгийн, шүдний болон мал эмнэлгийн багаж, төхөөрөмж, хиймэл шүд, нүд, сонсгол бэртэнгэ эмчлэх бүтээгдэхүүн, шархны материал
11. Гэрэлтүүлэг, халаалга, жигнэж боловсруулах, хоол хийх, хатаах агааржуулах, хөргөх, усан хангамж, ариун цэврийн зориулалтын хэрэгсэл
12. Хөдлөх бүрэлдэхүүн, газар, агаар, усаар явах хөдлөх бүрэлдэхүүнд зориулсан багаж
13. Галт зэвсэг, тэсрэх бодис, зэр зэвсэг болон харвадаг зэвсэг
14. үнэт металл болон үнэт металл эдлэл ба тэдгээрийн хайлш,бусад ангилалд ордоггүй эдгээр материалаар хийсэн эдлэл , бэлэг дурсгал, үнэт эдлэл, үнэт чулуу, хугацааны болон хронометрийн
15. Хөгжмийн зэмсэг
16. Цаас, шахмал цаас болон бусад ангилалд ороогүй эдгээр материалаар хийсэн эдлэл, хэвлэмэл хуудас, ном хавтаслах материал, гэрэл зураг, бичгийн хэрэглэл, бичиг хэргийн буюу гэр ахуйн цавуу, зураачийн хэрэгсэл, будгийн багс бийр, бичгийн машин болон албан ажлын зайлшгүй хэрэгцээт зүйлс (тавилгаас бусад), зааварчлах, багшлах машин (багажаас бусад), боодлын хуванцар материал, (бусад ангилалд орсноос бусад), хөзөр, хэвлэгчийн бар, хэвлэлийн иж бүрдэл
17. Резин, каучук, модны сүүн шүүс, бохь, гөлтгөнө болон эдгээр материалаар хийсэн бусад ангилалд ороогүй бараа, үйлдвэрлэлд хэрэглэх нягтруулсан хуванцар боодол, ломбо, тусгаарлах материал, металл бус уян хоолой
18. Савхи болон хиймэл савхи, бусад ангилалд ороогүй ширэн эдлэл, малын арьс шир, аяны хайрцаг, аяллын цүнх, нарны шүхэр, жижиг шүхэр, гар таяг, эмээл, эмээл болон морины тоноглол, ташуур
19. Барилгын материал (төмөр бус), барилгын металл бус хатуу хоолой, замын цардлага, газрын тосны шаарга, давирхай, металл бус зөөврийн байшин, металл бус хөшөө дурсгал .
20. Модон тавилга, толь, зургийн жааз, модон(бусад ангилалд ороогүй), сүрлэн, ясан, үйсэн, зэгсэн, хулсан, модон сүлжмэл, халимын сахлан, дунгаар хийсэн, байгалийн сувдан, далайн хөөсөөр хийсэн болон хуванцар эдлэл, эдгээр бүх материалыг орлуулагч

21. Гэр ахуйн болон гал тогооны сав суулга болон иж бүрдэл (үнэт метал бус тэдгээрээр бүрсэн), угаалгын сүвэрхэг бодис болон сойз, сагс (будгийн бус), багс хийх материал, цэвэрлэгээний бүтээгдэхүүн, ган хусуур, боловсруулаагүй болон хагас боловсруулсан шил (барилгын шилнээс бусад), шилэн сав, шаазан болон бусад ангилалд ороогүй шавар вааран сав
22. Ган татлага, олс, дээс, тор, сүүдрэвч, майхан брезент, завины далбаа, сагс, уут (бусад ангилалд ороогүй), дүүргэгч болон чигжээсний материал, /резин хуванцраас бусад/, сүлжмэлийн утасны түүхий материал
23. Сүлжмэлд хэрэглэх утас, ээрмэл
24. Сүлжмэл болон бусад ангилалд ороогүй сүлжмэл бараа, ор ширээний бүтээлэг.
25. Хувцас, гутал, малгай
26. Зээг чимэглэл, нэхмэл, тууз эмжээр, оосор, товч, шагайвар, дэгээ, зүү, шор зүү, битүү зүү, хиймэл цэцэг.
27. Хивс, хивсэнцэр, шалны хивс, хулдаас, зузаан хулдаас, шаланд дэвсэх бусад материал, хананы (сүлжмэл бус)
28. Тоглоом наадгай, бусад ангилалд ороогүй биеийн тамир, гимнастикийн хэрэгсэл, гацуур модны чимэглэл.
29. Мах, загас, гэрийн шувуу болон ангийн шувууд, ангилсан мах, хадгалсан, хатаасан, боловсруулсан жимс, хүнсний ногоо, нухаш, жимсний шүүс, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүн, идэшний өөх тос
30. Кофе, цай, какао, элсэн чихэр, цагаан будаа, далдууны сата, хушуу будаа, хиймэл кофе, гурил, будааны гурилын бэлдмэл, талх, гурилан бүтээгдэхүүн, чихэр, мөхөөлдөс, зөгийн бал, бурам, хөөсөн, жигнэмэл нунтаг, давс, гич, сүүмс, цуу(амтлах), амтлагч,
31. Хөдөө аж ахуй, цэцэрлэгийн, ойн аж ахуйн бүтээгдэхүүн, бусад ангилалд ороогүй будаа, амьд амьтан цэвэр жимс, хүнсний ногоо, үр, байгалийн ургамал, цэцэг, малын хоол тэжээл, амуу соёо
32. Шар айраг, рашаан, хийжүүлсэн ус, спиртийн бус ундаа, жимсний дарс, жимсний ундаа, жимсний шүүс, сироп, ундаа хийх бусад
33. Согтууруулах ундаа (шар айрагнаас бусад).
34. Тамхи, тамхи татах хэрэгсэл, чүдэнз

ҮЙЛЧИЛГЭЭ

35. Зар сурталчилгаа, бизнесийн үйл ажиллагаа, бизнесийн удирдлага, байгууллагын үйл ажиллагаа
36. Даатгал, санхүүгийн харилцаа, мөнгөний харилцаа, биет хөрөнгийн харилцаа
37. Барилга барих, зохион бүтээх, засвар, суурилуулах үйлчилгээ
38. Холбооны үйлчилгээ
39. Тээвэр барааг хадгалах болон савлах, аялал зохион байгуулах
40. Материалын боловсруулалт
41. Боловсрол, сургалт явуулах, хүлээн авалт, спортын болон соёлын үйл ажиллагаа.
42. Шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ, судалгаа, загвар, үйлдвэрийн судалгаа, шинжилгээний үйлчилгээ, компьютерийн програм хангамж болон техник хангамжийг хөгжүүлэх үйлчилгээ, загвар, эрхзүйн үйлчилгээ
43. Хүнс болон ундааны хангамжийн үйлчилгээ, буудлын захиалга
44. Эмнэлгийн, эрүүл ахуйн, гоо сайхны, сувиллын үйлчилгээ, мал эмнэлэг, хөдөө аж ахуй, ойн аж ахуйн үйлчилгээ
45. Нэг буюу хэд хэдэн хүн, хамт олонд үзүүлэх үйлчилгээ, хувийн болон өмч хамгаалалтын нууцлалын үйлчилгээ

2003 оны 6-р сарын байдлаар Ниццийн Хэлэлцээрийн гишүүн 72 орон байна. Тэдгээр нь барааны тэмдгийн бүртгэлийн Ниццийн ангиллыг батлан хэрэгжүүлдэг.

Хавсралт III

Мадридын Холбооны гишүүд (2003 оны 11-р сарын байдлаар)

Албани (Х&П)	Лихтенштэйн (Х&П)
Алжир(Х)	Литви (П)
Антигуа Барбуда(П)	Люксембург (Х&П)
Армен (Х&П)	Монако (Х&П)
Австрали (П)	Монгол (Х&П)
Австри (Х&П)	Морокко (Х&П)
Азербайжан (Х)	Мозамбик (Х&П)
Беларус (Х&П1)	Нидерланд* (Х&П)
Бельги* (Х&П)	Норвеги (П)
Бутан (Х&П)	Польш (Х&П)
Босни Герцоговин (Х)	Португали (Х&П)
Болгар (Х&П)	Солонгос (П)
Хятад (Х&П)	Молдав (Х&П)
Хорват (Х)	Румын (Х&П)
Куб (Х&П)	ОХУ (Х&П)
Кипр (Х&П)	Сан Марино (Х)
Чех (Х&П)	Сьерра Леон (Х&П)
Ардчилсан Солонгос (Х&П)	Сингапур(П)
Дани (П)	Словак (Х&П)
Египет (Х)	Словени (Х&П)
Эстони (П)	Испани (Х&П)
Финлянд (П)	Судан(Х)
Франц (Х&П)	Свазиланд(Х&П)
Гүрж (П)	Швед(Р)
Герман (Х&П)	Швейцари (Х&П)
Грек (П)	Тажикистан (Х)
Унгар (Х&П)	Югослав
Исланд (П)	Македони (Х&П)
Ирланд (П)	Турк (П)
Итали (Х&П)	Туркменистан (П)
Япон (П)	Украйн (Х&П)
Казахстан (Х)	Англи (П)
Кени (Х&П)	АНУ (П)
Киргизстан (Х)	Узбекистан (Х)
Латви (Х&П)	Вьетнам (Х)
Лесото (Х&П)	Югослав (Х&П)
Либерии (Х)	Замби (П)

(Х) Хэлэлцээрийн гишүүнийг заана (54)

(П) Протоколын гишүүнийг заана (59)

Энэхүү гарын авлагыг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагийн төслийн хүрээнд Б.Оюунцэцэн үндэсний нөхцөлд тохируулан хөрвүүлж Монгол Улсын Оюуны Өмчийн Газраас эрхлэн гаргав.

Хаяг: Монгол Улсын Оюуны Өмчийн Газар
Улаанбаатар-46, Бага тойруу-49
Утас: 329671
Факс: 327638
И-мэйл: ipom@magicnet.mn
Вэбсайт: www.ipom.mn

Санамж: Энэхүү гарын авлагад агуулагдаж буй мэдээллийг мэргэжлийн эрх зүйн зөвлөлтөө гэж ойлгож болохгүй юм. Энэ гарын авлагын зорилго нь үндсэн мэдээлэл өгөхөөр хязгаарлагдана.

Монгол Улсын Зохиогчийн эрхийн хуулийн дагуу зохиогчийн эрх эзэмшигчээс бичгээр авсан зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийн аль нэг хэсгийг ямар нэгэн хэлбэрээр эсвэл аль нэг зорилгоор, цахим болон механик аргаар хуулбарлахыг хориглоно.